



# СОЁМБО

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

214 /214/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.12.30

## ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

### НЭГ УДААГИЙН ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ ГАРДУУЛЛАА



Сүүлийн хоёр жил орчим хугацаанд дэлхий нийт коронавирусийн халдварын хүндхэн нөхцөл байдалд ажиллаж, амьдарч байна. Цар тахал аюулын харанга дэлдэж буй энэ цаг үед БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах "UNMISS" ажиллагаанд үүргээ амжилттай гүйцэтгэсэн Х ээлжийн мотобуудлагын батальоны бие бүрэлдэхүүн "Ковид-19"-ийн улаан бүсэд үүрэг гүйцэтгэж буй Цэргийн төв эмнэлэг болон ЗХЖШ-ын Эрүүл мэндийн хэлтэст нэг удаагийн 600 гаруй хамгаалах

хувцас, хэрэгслийг гардуулан өглөө.

Энэ үеэр Цэргийн төв эмнэлгийн дарга, ерөнхий эмч хурандаа Б.Энх-Од хэлсэн үгэндээ "Цар тахлын өвчлөл өдрөөс өдөрт өргөжиж байгаа энэ хүнд хэцүү үед та бүхний тусламж, дэмжлэг тун цаг үеэ олсон үйл явдал боллоо. Энэ бол цэргийн алба хаагчдад хүргэж байгаа том тус болж байна" гэдгийг хэлээд Х ээлжийн мотобуудлагын батальоны нийт бие бүрэлдэхүүнд цаашдынх нь ажил, амьдралд нь сайн сайхан бүхнийг хүсэн ерөөлөө.

## ОНЫ АВАРГУУД ТОДОРЛОО



### Зэвсэгт хүчний 350 дугаар анги

Тус анги жилийн эцсийн тайлангийн хурлаа хийж оны шилдгүүдэд тодрууллаа. Баярын арга хэмжээнд ТХЦК-ын Цэрэг-Иргэний харилцааны хэлтсийн дарга дэд хурандаа Ү.Хүрлээ, Монгол Улсын заан Ц.Одбаяр нар хүрэлцэн ирлээ. Бие бүрэлдэхүүнийг жагсааж захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга дэд хурандаа Б.Ууганбаяр ангийн байлдааны тугийг жагсаалд залж ангийн захирагч хурандаа Ж.Сүх-Очирт илтгэл өгснөөр арга хэмжээг эхлүүлээ.

Үүний дараагаар бие бүрэлдэхүүнтэй цэргийн тангараг давтаж ангийн захирагч хурандаа Ж.Сүх-Очир нийт бие бүрэлдэхүүнд хандан Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 110 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлсэн юм. Үргэлжлүүлэн

бие бүрэлдэхүүнийг спорт зааланд хүлээн авч 2021 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлангаа хэлэлцлээ. Төгсгөлд нь улиран одож буй 2021 онд эрхэлсэн ажил албандаа амжилт гаргасан хөдөлмөрийн аварга, тэргүүний алба хаагч, нэгж, салбарт шагнал гардуулах ажиллагааг зохион байгуулав.

ЗХЖШ-ын даргын тушаалаар 1МБР-ын захирагч ахлах дэслэгч Т.Нацагдорж албан тушаалын зэрэглэлийн дагуу ахмад, дотрын эмч дэслэгч Б.Буянхишиг ахлах дэслэгч цол хүртлээ. Мөн 50 гаруй алба хаагчийг өвлийн өвгөний бэлгээр шагнаж урамшууллаа. Арга хэмжээний үеэр тус ангид ажиллаж байгаад өөр анги, байгуулагд шилжин дэвшин томилогдсон 17 офицер, ахлагчийг хүлээн авч гарын бэлгэ гардуулан тэдний цаашдын ажил албанд нь ажлын их амжилт, эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөж урлагийн тоглолтыг толилууллаа.

## САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ӨРГӨТГӨСӨН ХУРАЛДААН БОЛЛОО



ЗХЖШ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөлийн ээлжит хуралдааныг энэ сарын 30-ны өдөр зохион байгуулж, хуралдааныг ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга бригадын генерал С.Ганбямба удирдан явууллаа. Хуралдаанд ЗХЖШ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөлийн гишүүд болон ЗХЖШ-ын Зохион байгуулалтын бүтцийн нэгж, Төрлийн цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газар, нэгтгэл, ангиудын салбар зөвлөлийн дарга, гишүүд оролцож, өргөтгөсөн байдлаар зохион байгуулсан юм.

Хуралдааны эхэнд ЗХЖШ-ын Цэргийн албаны хэлтсийн дарга хурандаа Н.Лхагвасүрэн ЗХЖШ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөлийн болон

ЗХЖШ-ын Зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, төрлийн цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газар, нэгтгэл, ангиудын салбар зөвлөлийн 2021 оны нэгдсэн тайлан, ирэх оны үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулав. Дараа нь ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга бригадын генерал С.Ганбямба 2021 онд гарсан гэмт хэрэг, осол, сахилгын зөрчилд дүгнэлт хийж, ЗХЖШ-ын Зохион байгуулалтын бүтцийн нэгж, Төрлийн цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газар, нэгтгэл, анги, байгууллагуудын салбар зөвлөлийн дарга нарт үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг нь ханган ажиллахыг анхаарууллаа.

Ийнхүү ЗХЖШ-ын салбар зөвлөлийн ээлжит хуралдааныг өргөтгөсөн байдлаар зохион байгуулж, тулгамдсан асуудал, цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг тодорхойлсон юм.



## ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛЫН ТЭРГҮҮНҮҮД ТОДРОВ



Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалынхан 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө дүгнэж, тэргүүнүүдэд тодрууллаа. Хуурай замын цэргийн командлалын 2021 оны "Тэргүүний офицер"-оор Мэдээллийн аюулгүй байдлын офицер, хошууч Д.Мөнхтүвшин, "Тэргүүний ахлагч"-аар Хуурай замын цэргийн ахлагч, тэргүүн ахлагч Д.Мөнхбаяр, "Тэргүүний

ажилтан албан хаагч"-аар Хангалт үйлчилгээний тасгийн ажилтан албан хаагч Т.Эрдэнэханд нар шалгарсан бол "Хуурай замын цэргийн тэргүүний салааны захирагч"-аар Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн зөвлөлийн салааны захирагч, дэслэгч Б.Батзаяа тодорсон юм. Шагналыг Хуурай замын цэргийн штабын дарга, бригадын генерал Л.Онцгойбаяр гардуулж, баяр хүргэлээ.

## Түүхэнд энэ өдөр

1911 он.

Монгол Улсын Дотоод яамнаас эрхлэн "Дээрээс шагнасан тамгыг хүлээн авч харьяат яамны хиур туг залж, хэрэг шийтгэх явдлыг Сангийн яамны зэрэг есөн газарт явуулан тушаасан" байна.

1983 он.

БНМАУ-ын СнЗ-ийн 339 дүгээр тогтоолоор Ардын Армийн төв эмнэлгийг Клиникийн төв эмнэлэг болгов.

## ЦАГ АГААР

### УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ -11	🌧️ -29

### ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 37	🌧️ 24

## ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2,846.0	2,851.0
EUR 🇪🇺	3,225.0	3,237.0
CNY 🇨🇳	431.00	436.00
RUB 🇷🇺	36.38	39.10
JPY 🇯🇵	24.90	25.00
KRW 🇰🇷	2.39	2.40

## ЗУРХАЙ




2021.12.30 ЛХАГВА ГАРАГ  
/БИЛГИЙН ТООЛЛЫН 26/

## ӨВЛИЙН ДУНД ЦАГААН ХУЛГАНА САРЫН ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ ЦАГААН НОХОЙ ӨДӨР ҮС ЗАСУУЛАЛ:

Өвчин эмгэг ирнэ  
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:  
08.41-17.06  
БАРИЛДЛАГА: Түлэх  
ШҮТЭН БАРИЛДЛАГА: Нэр өнгө  
Суудал: Төмөр

Энэ өдөр бар, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамагй хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын авшиг авах, шинэ гэр ба байр авах, угаал үйлдэх, хүүхэд үрчлэн авах, андгай тангараг, гэрээ, хэлцлээ буцаахад сайн. Нүүдэл суудал хийх, хэрүүл тэмцэл хийх, хүүхэд хөлд оруулахад муу.

Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.



# ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ НЭГТГЭЛ, АНГИ, САЛБАРУУД 2021 ОНЫ ТЭРГҮҮНҮҮД ТОДОРЛОО

## Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл



Нэгтгэлийн 2021 оны "Тэргүүний хамт олон"-оор хошууч А.Ганболд захирагчтай Мотоуудлагын батальон, Тэргүүний офицер"-оор соёл хүмүүжлийн албаны дарга хошууч Д.Долгоржав, "Тэргүүний ахлагч"-аар ахлах ахлагч А.Цэрэнпүрэв, "Тэргүүний ажилтан алба хаагч"-аар тогооч У.Батцэцэг, "Тэргүүний тамирчин"-аар ахмад Б.Даваадорж нар шалгарч өргөмжлөл, дурсгалын тууз, мөнгөн шагналаар шагнагдлаа.

**Хошууч**  
**Д.Долгоржав**

## Зэвсэгт хүчний 234 дүгээр анги



Цэргийн гавьяаны одонт Зэвсэгт хүчний 234 дүгээр анги 2021 оны үйл ажиллагааны тайлангийн хурлыг зохион байгуулж, ажил үйлсээрээ бусдыгаа манлайлагч хамт олон, тэргүүнүүдэд тодрууллаа.

"Тэргүүний хамт олон"-оор дэд хурандаа Б.Бодьхүү даргатай "Штабын хамт олон", "Тэргүүний офицер"-оор ахлах дэслэгч Б.Маралхүү, "Тэргүүний ахлагч"-аар ахлах



ахлагч Д.Оргилсайхан, "Тэргүүний цэргийн гэрээт алба хаагч"-аар дэд түрүүч Д.Бат-Эрдэнэ, "Тэргүүний ажилтан"-аар Ж.Нямхүү, "Бүтээлч хамт олон"-оор ХГР, ДГР-ын хамт олон шалгарсан бөгөөд ангийн захирагч хурандаа Г.Эрдэнэбаяр шагналыг нь гардуулан өгсөн юм.

Мөн энэ үеэр шинэ жилийн баярыг угтан бие бүрэлдэхүүний дунд зохион



байгуулсан "Цогцолбор" тэмцээний ялагчдын шагналыг гардуулав. Тодруулбал, эл тэмцээний 1 дүгээр байрт хурандаа Г.Эрдэнэбаяр ахлагчтай баг, 2 дугаар байрт ахлах ахлагч Б.Батпүрэв ахлагчтай авто тээвэр, засварын салааны баг, 3 дугаар байрт ахлах дэслэгч Б.Ганболд ахлагчтай Хөвүүр гүүрийн ротын III баг тус тус шалгарсан юм.

**Дэслэгч**  
**Ч.ОЮУНЧИМЭГ**

## Зэвсэгт хүчний 032 дугаар анги

2021 оны жилийн эцсийн тайлангийн хурлыг 12 дугаар сарын 24-ний өдөр зохион байгууллаа. Хурлын үеэр ажил үйлсээрээ хамт олноо манлайлагчдыг тодруулж шагналыг гардуулан, азын сугалаа явуулж, шинэ жилийн 30 ширхэг бэлгийг азтануудад өгч баяр дээр баяр нэмлээ.

Ангийн 2021 оны "Тэргүүний хамт олон"-оор Соёл хүмүүжлийн алба, "Тэргүүний офицер"-оор Сургалтын албаны төлөвлөлтийн офицер ахлах дэслэгч А.Цогтбилэг, "Тэргүүний ахлагч"-аар Үлээвэр найрал хөгжмийн ахлах хөгжимчин, нарийн бүрээчин МУСТА ахлах



ахлагч Г.Батбаяр, "Тэргүүний тамирчин"-аар ОУХМ ахлах ахлагч Ч.Батжаргал, "Тэргүүний дэд түрүүч"-ээр ХХТР-ын дэд түрүүч Б.Эрдэнэдаваа, "Тэргүүний байлдагч"-

аар ХҮТР-ын байлдагч Б.Төрболд, "Тэргүүний ажилтан"-аар Орон сууц ашиглалтын албаны сантехникийн слесарь Ш.Ганбат нар шалгарлаа.

## Зэвсэгт хүчний 284 дүгээр анги

Сургуулийн жилийн 2021-2022 оны ангийн аварга шалгаруулах спортын цогцолбор тэмцээнийг сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннис, дартс, шатар, даам гэсэн төрлөөр зохион байгуулж шилдгүүдийг

шалгарууллаа. Тодруулбал, нийлбэр дүнгээр тэргүүн байрт ахмад З.Алтаншагай, дэд байрт хошууч Я.Амартүвшин, гутгаар байрт хошууч Батболд ахлагчтай баг тамирчид тус тус шалгарлаа.

Мөн 2021 оны

"Тэргүүний офицер"-оор АУТ-ийн дайчилгааны офицер ахмад Т.Батсуурь, "Тэргүүний ахлагч"-аар БЗГХТ-ийн зураг зүйн техникч-агуулахын нярав ахлах ахлагч Э.Даваадалай, "Тэргүүний ажилтан албан хаагч"-аар нярав Д.Наранчимэг нар шалгарлаа.

Мөн "Шинэ жилийн баярын шилдэг мэндчилгээ" шалгаруулах уралдааны удирдамжийн дагуу бие бүрэлдэхүүний хамт олонч нөхөрсөг уур амьсгалыг дээшлүүлэх, нийгмийн идэвхийг нь нэмэгдүүлэх, шинэ жилийн баярын уур амьсгалыг бүрдүүлэхэд чиглэн ажилласан. Уг арга хэмжээнд нийт 2 алба, 5 тасаг оролцсон бөгөөд 1 дүгээр байрт АУТ, 2 дугаар байрт ЦУХТ, 3 дугаар байрт БЗГХТ шалгарсан юм.



## Зэвсэгт хүчний 014 дүгээр анги

Ангийн бие бүрэлдэхүүн 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсын цэргийн тангараг давтаж, нэгдсэн

тооллого явууллаа. Ангийн 2021 оны "Аварга офицер"-оор захирагчийн орлогч-ерөнхий инженер дэд хурандаа Б.Ганбаатар, "Аварга ахлагч"-

аар харуулын салааны ахлагч, харуулын дарга ахлах ахлагч Л.Вандантүгж, "Аварга ажилтан"-аар цэргийн гал тогооны тогооч Ё.Цэенханд,



"Аварга цэргийн гэрээт алба хаагч"-аар инженер сапёрын ротын инженер техникийн салааны замын ажлын тасгийн ПКТ-2-ын туслах механик жолооч түрүүч Б.Гүррагчаа, "Тэргүүний хамт олон"-оор орон сууц ашиглалтын хэсгийн хамт олон тус тус шалгарлаа. Мөн ангийн захирагчийн тушаалаар

зарим цэргийн алба хаагчдад Монгол Улсын цэргийн цол олгож, Монголын залуучуудын холбооны шагнал "Цэргийн алдар", "Тамирчны алдар", Монголын соёлын ажилтны "Соёлын түшиг" холбооны дээд шагнал "Соёлын алдар" зэрэг медаль, ангитай хамтран ажиллагч байгууллагуудын гарын бэлгээр зарим цэргийн

алба хаагчид шагнагдаж ангийн захирагч хурандаа Г.Эрдэнэбаатар болон ангийн удирдлага шагналыг гардуулж өглөө. Энэ үеэр ангийн шинэ жилийн баярт зориулж Үлээвэр найрал хөгжмийн хамт олон "Мөнгөн эгшиглэн" тайлан тоглолтоо ангийн удирдлага, бие бүрэлдэхүүнд өргөн бариллаа.

**Дэслэгч Р.БИЛЭГ**

## Зэвсэгт хүчний 339 дүгээр анги



Энэ сарын 28-ны өдөр 2021 оны үйл ажиллагааны тайлангийн хурлаа зохион байгуулж явууллаа. Хурлын үйл ажиллагаанд Баянхонгор аймгийн ЗДТГ-ын дарга хагатай Г.Энхжаргал, ЗДТГ-ын Цэргийн штабын дарга хурандаа Нэмэхбаяр, Цагдаагийн газрын дарга цагдаагийн хурандаа

Оюутболд, Баянхонгор аймгийн прокурорын газрын дарга Амарбаясгалан болон ангийн байнгын бие бүрэлдэхүүн оролцлоо. Ангийн 2021 оны "Тэргүүний хамт олон"-оор ахлах дэслэгч Г.Чинзориг даргатай "Эрүүл мэндийн төв", "Тэргүүний бүтээлч хамт олон"-оор ахлах дэслэгч

Д.Даваасүрэн захирагчтай Барилга угсралт, засварын рот, "Тэргүүний офицер"-оор Захиргааны удирдлагын тасгийн хүний нөөцийн офицер ахмад Б.Баярмагнай, "Тэргүүний ахлагч"-аар Барилга угсралт, засварын ротын тасгийн захирагч ахлах ахлагч З.Батхуяг, "Тэргүүний барилгачин"-аар Замын ротын ахлагч Г.Наранбаатар, "Тэргүүний ажилтан албан хаагч"-аар Цэргийн гал тогооны тогооч Цэндээ, "Өсөх ирээдүйтэй барилгачин"-аар ахлагч Э.Төмөрчөдөр, дэд ахлагч О.Энхмаа, "Тэргүүний цэргийн гэрээт алба хаагч"-аар Замын ротын байлдагч Төмөрхуяг нар тус тус шалгарлаа.

Мөн ЗХЖШ-ын болон БИЦУГ-ын 2021 оны "Тэргүүний цэргийн гэрээт алба хаагч"-аар Замын ротын салааны замчин байлдагч Ж.Шаравням шалгарсан юм.

### ТУСГААР ТОГТНОЛЫН ХӨШӨӨНД ЦЭЦЭГ ӨРГӨВ

Монгол Улс Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 110 жилийн ойг тохиолдуулан энэ сарын 29-ний өдөр Баянхонгор аймгийн удирдлагууд, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын бие бүрэлдэхүүн Баганат талбай дахь "Тусгаар тогтнолын хөшөөнд" цэцэг өргөн хүндэтгэл үзүүлжээ.

**Ахмад**  
**С.АМАРЖАРГАЛ**

## УУЛЫН ДАЙЧИД 30 КМ МАРШ ҮЙЛДЛЭЭ

Зэвсэгт хүчний 331 дүгээр анги цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу 30 км-ийн маршийг ангийн офицер, ахлагч нарын гар нийлэмжтэй ажиллагааг хангаж, сэтгэл зүйн бэлтгэлжилтийн түвшнийг дээшлүүлэх, мэдлэг, дадлага, ур чадварыг хөгжүүлэх зорилгоор "Уулархаг газар оронд дайсантай тулгарч болзошгүй нөхцөлд явган марш үйлдэх нь"-сэдвээр энэ сарын 16-ны өдөр зохион байгууллаа.

Ангийн нийт бие бүрэлдэхүүн "Цугларалт" дохиогоор ажиллаж ангийн байрлалд ирж, сургалт,

соёл хүмүүжлийн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, уулын ахлах офицер Э.Энхбаатар ангийн захирагчийн тушаалыг уншиж танилцуулан, хүн нэг бүрийн хувийн зэвсэг, хамгаалах хэрэгсэл, арантайгаар 09.00 цагт хөдөлгөөн үйлдэж, химийн цагийн байдал, газрын дайралт хийж бие бүрэлдэхүүний бэлтгэлжилтийн түвшнийг шалгалаа.

14.00 цагт түр амралтыг зохион байгуулж, хүн нэг бүрийн зэвсэгт үзлэг хийж, аранзны хүнсээр хооллолтыг зохион байгуулж, 19.45 цагт ангийн байрлалд ирэв.